



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2010 оны 10 сарын 07 өдөр

Дугаар 455

Улаанбаатар хот

Г Буцалтгүй тусламжийн тухай 7

Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Бүгд Найрамдах Унгар Улсын Боловсролын яам, Үндэсний соёлын өвийн яам хооронд байгуулсан “Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах төлөвлөгөө”, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 177 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад төрийн буцалтгүй тусламж олгох тухай журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2010-2011 оны хичээлийн жилээс Бүгд Найрамдах Унгар Улсын их, дээд сургуульд тэтгэлэггүйгээр суралцах хавсралтад дурдсан 4 оюутанд Сургалтын төрийн сангийн амжиргааны тэтгэлэгийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Бүгд Найрамдах Унгар Улсын Засгийн газрын бүрэн тэтгэлэгт /"А" категори/ хамрагдах болсонтой холбогдуулан Будапешт хотын Анагаах ухааны их сургуулийн 1 дүгээр ангийн оюутан Цогтбаатар овогтой Оюунтуяа, 2 дугаар ангийн оюутан Цэрэндорж овогтой Сонинбаяр нарт олгож буй Сургалтын төрийн сангийн амжиргааны тэтгэлэгийн буцалтгүй тусламжийг 2010-2011 оны хичээлийн жилээс зогсоосугай.


2. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 177 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад төрийн буцалтгүй тусламж олгох тухай журам”, “Гэрээний загвар шинэчлэн батлах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 451/318 дугаар тушаалын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, төлбөр тооцоо хийхийг Сургалтын төрийн сан/Д.Нансалмаа/-д, энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД



Ё.ОТГОНБАЯР

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын
2010 оны 10 дугаар сарын 04 ний өдрийн
43 дугаар тушаалын хавсралт



БҮГД НАЙРАМДАХ УНГАР УЛСЫН ИХ, ДЭЭД
СУРГУУЛЬД СУРАЛЦАХ ОЮУТНЫ НЭР

1. Загдхорлоогийн Санчир
2. Болдбаатарын Уянга
3. Батмөнхийн Жаргалмаа
4. Батжавын Одтушиг

- Биотехнологи
- Анагаах ухаан
- Мэдээллийн технологи
- Анагаах ухаан